



2019 оны 04 сарын 17-н өдөр

Дугаар А/237

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан сумын 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019 оны 4, 5-р саруудад зохион байгуулагдах газар эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

М.Отгонбат -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Нарийн бичгийн дарга :

Б.Батбаяр -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Гишүүд:

Г.Эрдэнэбат -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Бат-Оргил -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Б.Насанжаргал -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Г.Гантөгс -Зуунмод сумын Засаг даргын орлогч

Д.Амартүвшин -Зуунмод сумын ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн

Б.Хатанбаатар -Зуунмод сумын ИТХ-ын төлөөлөгч

Т.Пүрэвдулам -Зуунмод сумын газрын даамал

Р.Жавзандолгор -Зуунмод сумын газрын даамал

2. “Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу дуудлага худалдаа зохион байгуулахад шаардагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга /М.Отгонбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

010 000609